

ФОТО СЭТГҮҮЛЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Л.Норовсүрэн*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн зөвлөх профессор, шинжлэх ухааны доктор, профессор

Түлхүүр үг: баримт, дүрс, ёс зүй, осол, хариу үйлдэл, уншигчдын гомдол, зохиомж, дайн самуун, мэдээний ерөө, аппарат

Мэдээллийн технологи түргэн хурдацтай хөгжиж байгаа өнөө үед хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлчдийн ажил ихээхэн хөнгөлөгдөж, цаг үеэ шуурхай тусгахад нь дөхөм болж байгаа ч, нөгөө талд нь сэтгүүлчид аливаа мэдээллийг олж авахдаа хүнлэг чанар, ёс зүйгээ эрхэмлэх шаардлага нэгэн адил тавигдаж байгаа билээ. Ялангуяа орчин үеийн таниц сайтай, өндөр хурдтай аппарат хэрэгслээр зэвсэглэсэн фото сэтгүүлчид хүний амьдралын эрээнтэй бараантай явдлаас алийг нь, ямар шинжийг нь онцолж, хэнд зориулж фото хальсандаа буулгаж авах вэ гэдгийг эрхбиш бодож байх учиртай. Ялангуяа хүний хувийн, эд хөрөнгийн, эрүүл мэндийн, гэр бүлийн гэх мэт нууцтай холбоотой үйл явдал, баримтыг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр ил болон далдаас татаж авах нь сэтгүүлчийн ёс зүйд харш билээ.

Гэрэл зураг бол өнгөрсөн хийгээд өнөөдрийн явдлыг бодитой гэрч

баримтаар тусгаж авдаг итгэл үнэмшилтэй, хүчирхэг урлаг ба мэдээллийн зүйл юм. Гэрэл зурагчин аппаратны товчлуурыг дарах бүрд үйл явдал хувилагдаж байдаг. Ингэснээр болоод өнгөрсөн үйл явдлыг дахин сэргээж, хэчнээн ч хугацаагаар амилуулах бололцоотой болдог. Өөр үгээр хэлбэл хүнийг хийж байсан үйлдэлтэй нь хамт хадгалж үлдээлээ гэсэн үг. Тухайн үед хүн юу ч хийж байсан байж болно, түүнийгээ нууцлахыг хүсч байсан ч байж мэднэ. Бүр зураг авахуулах байтугай амьд явахад ч бэрх асуудалтай тулгарсан байж болно. Ялангуяа байгалийн гамшиг, аваар осол, золгүй явдлын үед хүмүүс сэтгэлийн дарамтанд орох нь их байдаг. Иймээс зурагчин хүн юуны зургийг, хэдийд, ямар байдлаар авах вэ? гэдгийг сайтар бодож, зөв шийдвэр гаргадаг байх ёстой.

Сэтгүүлчийн авсан зураг ба түүнд уншигчийн үзүүлсэн хариу үйлдлийг Америкийн судлаач Грег Хартлей судалсан байна. Фото сэтгүүлч машины осолд орсон жүжигчин эмэгтэйн зургийг хэргийн газар дээр аваад редакци руугаа яаралтай илгээжээ гэж бодъё. Г.Хартлейн олж тогтоосноор энэ

тохиолдолд уншигчдын 28,0 хувь нь зурагчныг сэтгүүлчийнхээ үүргийг гүйцэтгэсэн гэж үзсэн бол, 71,0 хувь буюу иргэдийн дөрөвний гурав нь сэтгүүлчийн үйлдлийг буруушаасан байна. Тэд "хүний зовлонгоор хоолоо олж идлээ" гэж зурагчинд зэвүүцсэн байжээ.

Сонины эрхлэгч нар хүчтэй, шилдэг зургуудыг сонгож нийтлэхийг урьдал болгодог. Гэвч амь насаа алдагсад, зэрэмдэг болсон бие, цус неж, эсвэл ойр төрлийнхөн болон гэрчийн нулимс асгаруулсан энэлэл шаналлыг харахад маш хүнд байдаг. Түүнээс гадна уншигчдын гомдол, уур бухимдлыг намжаана гэдэг бүр ч түвэгтэй асуудал юм. Нөгөө талаар ийм асуудлын цаана нийгмийн эрх ашиг гэж байдаг. Гуниг зовлонгоо нийтэд дэлгэх нь тухайн субьектэд хэцүү байсан ч, ослын үр дагаврыг харсан олон нийтэд зам тээврийн осолд орохгүйн тулд дүрмээ баримтлан, жолоогоо хянуур нямбай барих хэвшлийг төлөвшүүлдэг. Харин ийм үйл явдлыг үзүүлэхдээ сэтгүүлч аль болох эвлэг, зохимжтой хэлбэрийг эрэлхийлэх нь чухал юм.

Эрхлэгч нар сонины нийтлэлийг төлөвлөхдөө эдийн засгийн талаас нь бас хардаг. Энэ зураг, эсвэл бичвэрийг хэн унших вэ, ямар уншигч огт харахгүй өнгөрөх вэ? гэдэгт тэд санаа зовж байдаг. Уншигчдын нэг хэсэг нь сониныг гудамжнаас худалдан авдаг бол, олонх нь тодорхой хугацаагаар захиалж уншдаг. Хоёр дахь бүлгийн уншигчид нь эрхлэгч нарын сэтгэлийн зовлонг бага боловч хөнгөлж байдаг. Өдөр тутмын сонины хувьд эхний нүүр борлуулалтанд төдий л их нөлөөлдөггүй аж. Харин шар хэвлэлүүд эхний

нүүрэнд тавьсан зургуудаараа өнгөлөг зүйлд дуртай уншигчдыг татдаг байна. Орчин үеийн сонины эрхлэгчид нэг удаа худалдаж аваад больдог биш, байнгын тогтвортой уншигчдыг хайж байдаг. Үүнтэй холбоотойгоор уншигчдын хандлагад тулгуурлаж шийдвэрээ гаргах уу, эсвэл тэдний дур сонирхлыг үл харгалзан давуу байдлаа ашиглах уу? гэсэн хоёр сонголтын өмнө тулж ирдэг юм.

Эмгэнэлт явдлын түүхийг гэрэл зургаар баталгаажуулан нийтлэхийн тухайд сэтгүүлчид өөр өөр бодолтой байдаг. Бичгийн нийтлэл, фото нийтлэл хоёрын тусгаж байгаа зүйл газар зүйн хувьд хол, ойр байхаас мэдээний үнэ цэн ихээхэн шалтгаалдаг байна. Энэ нь тухайн үйл явдлын өөрт хамаатай, чухал, бодитой байдлыг үнэлэх үндэс болдог аж. Харин уншигчдын олонх нь орон нутагт нь болсон таагүй явдлын айдас хүргэм хүнд зургийн талаар ихээхэн гомдол гаргадаг нь тийм явдлаас хол байхыг хүсдэгтэй нь холбоотой байдаг.

Эрхлэгч нар ч таагүй явдлын зурганд орсон жирийн хүмүүсийн зургийг далдлан бүдгэрүүлэхийг хичээдэг. Тэгсэн хэдий ч дэлхийн өөр нэг газар нутагт түүнээс ч илүү айдас түгшүүр дагуулсан үйл явдлыг илчлэн нийтэлсээр байдаг юм. Бодит байдал дээр сонинуудад иймэрхүү асуудлыг зохицуулах шаардлага байнга гарч байдаг. «Трибун» сонины ажилтан Дэнис Коста хэлэхдээ «Зургийг нь авах гэж байгаа этгээдээс илүүтэйгээр түүнийг аврах гэж байгаа хүнийг дүрслэхийг би хүсдэг» гэжээ. Зарим судлаач үүнийг түүхийг хувилан үлдээх уламжлалт мэдээний эсрэг хандсан хэрэг гэсэн нь ч бий. Эрхлэгч нар уурлаж бухимдсан

уншигчийн дуудлагыг хүлээн авах дургүй байдаг ч, зургийн ёс зүйтэй холбоотой асуудал хэзээ ч тасардаггүй.

Сэтгүүлчийн ёс зүйн тухай ярих бүрд заавал хөндөгддөг асуудлын нэг нь үхсэн хүний зураг байдаг. Сониныхон өөрсдөө авсан, эсвэл тэдний гар дээр ирсэн үхсэн хүний зургуудыг эрхлэгч нар л зохицуулдаг.

Буруудах, зөвдөхийн аль аль нь бий. Жишээ нь «Detroit Free Press» сонин Детройтийн гал сөнөөгч амь насаа алдсан зургийг тэргүүн нүүрэндээ маш том хэмжээгээр тавьснаас болж бөөн шуугиан дэгдсэн байна. Уг зургийг нийтэлсний зөв, бурууг асууж явуулсан судалгаагаар уншигчдын санал тэнцүү

хуваагдсан гэж тус сонины зургийн найруулагч Майк Смит мэдэгджээ. Харин тоймч Сюзан Ватсон зөв гэсэн хатуу байр сууриа илэрхийлсэн байна. «Утсаа шүүрч аваад залгадаг зарим хүмүүс “Энэ чинь жигшүүртэй, ой гутмаар, тохиромжгүй зураг байна” гэдэг. Тэгвэл энэ цаасан дээр яагаад дандаа сайхан амттай юм бичих ёстой гэж? Тэгэхээр над руу дуудлага ирсэн ч авахгүй байх нь зөв юм. Хэрэв ингэвэл нэг ч гэсэн хуудас цаас ажлаа хийг л дээ. Би л байсан бол энэ зургийг бүтэн хуудас дамнуулан тавих байсан даа. Яагаад болохгүй гэж? Би л хувьдаа зогсохгүй. Аварга том хөрөг хийгээд энэ байрны орой дээрээс, эсвэл Сити Холл, Капитол, Лангсингээс ч өлгөсөн яадаг юм. Би хүүхдүүдээ эрсдэлд

оруулбал шударга бус үнийг төлөх халуу шатам сануулгыг тэдэнд л өгөх байсан. Бид өөрсдийн хайртай хүмүүсийг аюулаас холдуулахын тулд аймшигтай, чанга, бүдүүлэг зүйлүүдийг хийх л болно»¹ гэж тэр хэлжээ.

Дэлхийн II дайны эхэн үеийн сонин хэвлэлүүд, тухайлбал Америкийн хэвлэлүүд өөрийн цэргүүдийн үхэж үрэгдсэн зургийг хэвлэн нийтэлж байгаагүй юм. Учир нь цэрэг эрсийн ар гэрийнхэн болон иргэдийн итгэл, тэдний сэтгэл санаа, ёс суртахууныг хадгалж үлдэхийг эрхлэгч нар хичээж байв. «Лайф» сэтгүүл анх удаа дэлбэрэлтээс болж далайн эрэг дээр шидэгдэж үхсэн америк цэргүүдийн зургийг нийтлэх хүртэл хэвлэлүүд дайны хор уршгийг нууж байв.

Ийм аргаар олон нийтийг хамгаалах нь хэвлэл мэдээллийн үүрэг үү, эсвэл эрх үү? Энэ мэт үйлдлүүдийг нууснаараа хэвлэл мэдээлэл Европд өргөжин тэлж буй харгис хэрцгий явдлаас америкчуудыг урьдчилан сэргийлж чадсан гэж үзэж болох уу? Уур хилэн дайнд амжилт олоход нөлөөлөх боломжтой юу? гэх мэт олон асуултад хариулт өгөх хэрэгтэй юм.

«Ассошиэйтэд Пресс»-д мэдээ бэлтгэдэг байсан Себастиан Балик Өмнөд Америкт нэгэн эр лүү чулуу шидэж, улмаар жадалж, эцэст нь галд шатааж байгаа айдас төрүүлэм зураг авчээ. «The New York Daily News» чулуу шидэж байгаа зургийг нь нийтэлсэн юм. Тэр зургуудыг ашиглаж

«

Сэтгүүлчийн ёс зүйн тухай ярих бүрд заавал хөндөгддөг асуудлын нэг нь үхсэн хүний зураг байдаг. Сониныхон өөрсдөө авсан, эсвэл тэдний гар дээр ирсэн үхсэн хүний зургуудыг эрхлэгч нар л зохицуулдаг.

»

нийтлэл бичсэн Сью О'Брайены талаар ням гаригийн сонины эрхлэгч Жэфф Жарвис «Өглөөний цайг шалгах нь ерээд оныхны төлөө ажиллаж байгаа хэрэг гэж бодохгүй байна» гэжээ. Түүнийг нь «Minneapolis Star Tribune»-ийн зургийн редактор Майк Зэрби хүлээн зөвшөөрсөн байдаг. Тэрбээр «Стандарт шугам бол бидэнд өөрсдийнхөө үндэс мөчрийн цусыг гаргах хэрэггүй гэсэн үг. Гэвч миний бодлоор энэхүү тусгай сонин гарснаар бид аль хэдийнэ ургаад эхэлчихэж»² хэмээн дүгнэсэн билээ.

Баруун хойд Их сургуулийн Куртим Мак Дугалыг хуучин «St. Luis Star Times»-д сэтгүүлчээр ажиллаж байхад нь ямар ч шүүх хурал болоогүйгээр хүнийг цаазаар хороосон хэргийн зургийг ашиглаж болох эсэх талаар мэдээний өрөөнд байсан сэтгүүлчдийн үзэл бодлыг сонсох гэж Ерөнхий эрхлэгч нь бүтэн цаг ярилцаж байсан тухай дурссан байна. Мак Дугал гэрэл зураг болон үүссэн хэргийг эргэж дурсаад «Зураг дээр цаазлуулж байгаа хүний нүүр огт гараагүй байсан. Харин биеийг нь харлуулж, дээр нь "X" тэмдэг тавьсан байсан» гэжээ.

Иймэрхүү хуучинсаг үзэл нь харгис хэрцгий эрүүдэн шүүх явдал африк гаралтай америкчуудын аллагын үеийн америк эрхлэгчдийн хэв шинж байсан юм. Мак Дугалын ярьсныг үндэслэвэл тэр цагт мэдээний өрөөнд орсон л бол тэнд байгаа зурагнуудын олонх нь хүнлэг бус, хэрцгий харьцаж байсныг нотолж байдаг ба сонинд нийтлэгдсэнээсээ цаасан баримтаар нь харахад илүү сонирхол татдаг байжээ. Үхсэн хүний өөр нэг зургийг үзээд Эрнест Мэйр «Байж боломгүй, цочирдмоор зураг. Энэ бол яах аргагүй гэмт хэрэг»

гэж «Capital Times»-д бичжээ. Хачирхууштай нь тэдгээр зураг үйл явдлын талаар ямар ч үгнээс илүүг хэлж байжээ.

Тэр үед сонины эрхлэгчид үхсэн хүний зургийг нийтлэх нь хэтэрхий айдас төрүүлэх зүйл мөн гэдэг дээр санал нийлдэг байсан ч, тахир дутуу болсон, цус нөж нь олгойдсон хохирогчийн жихүүдэс төрүүлэм зургуудыг нийтэлдэг байжээ. Эрхлэгч нар анхаарал болгоомжгүйгээр машин жолоодож байгаа хүмүүсийг сэрэмжлүүлэх зорилгоор ослын зургийг ухаалаг болгоомжтой нийтэлдэг байв. Тэр нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зохих нөлөө үзүүлжээ. Харамсалтай нь ийм зургууд эерэг үр дүн авчирна гэж хэн ч боддоггүй бөгөөд, харин ч гудамжны бүлэг этгээдүүдийн хүчирхийллийг өдөөнө гэж дургүйцдэг байна.

Манай хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа телевизүүд авто машины осолд орж, алуурчны гарт өртөж амиа алдсан хүний цус нөжиндөө будагдсан цогцсыг эрээ цээргүй үзүүлдэг нь нэгд, нийгмийн сэтгэл зүйд таагүй уур амьсгал төрүүлж, хоёрт, хүний эрхийг зөрчсөн ёс зүйн ноцтой алдаа юм. Үүнээс гадна хүний зургийг нууцаар авах, эвлүүлэх аргаар гүтгэх, адгуусан амьтанчлах зэргээр эрхэнд нь халддаг явдал нэлээд түгээмэл байна. Ерээд онд манай сонинууд төр, засгийн тэргүүнүүдийн зургийг элдэв амьтны дүрд хувилган нийтэлж байсныг мартаагүй байна. Тухайлбал: Ерөнхийлөгч П.Очирбатыг бар, Ерөнхий сайд П.Жасрайг мич болгон дүрсэлж байсан нь хүнийг гадаад төрх, зүс царайгаар нь доромжилсон ёс зүйгүй

үйлдэл болсон юм. Түүнчилэн “Эрдэнэт” үйлдвэрийн ерөнхий захирал Ш.Отгонбилэг үйлдвэрийнхээ тэргүүний ажилчин Буянтогтоход шагнал гардуулан гар барьж баяр хүргэсэн зургийг Ерөнхийлөгч Н.Багабандитай гар барьж байгаагаар эвлүүлээд «Атгасан гар алдраагүй цагт андын нөхөрлөл цуцрахгүй» гэсэн тайлбар хийсэн байв. Энэ нь Ш.Отгонбилэг өөрийн найз Н.Багабанди, Ц.Балдорж хоёрыг “Эрдэнэт” үйлдвэрийн мөнгөөр тэтгэж баяжуулсан гэдэг хов живийг үнэн болгох гэж оролдсон явуургүй арга болсон юм.

Ө нөө үед дэлхийн аль ч улс оронд автын осол улам бүр нэмэгдсээр байна.

Цагдаагийнхан осолд орж амь алдагсад болон гэмтэж бэртсэн хүмүүсийг түргэн зуур холдуулдаг болчихсон учир зургийг нь авах боломж ч хомс болсон. Гэвч дараах ёс суртахууны асуудал үлдэж байна. Тэр нь, ослын улмаас нас барсан хохирогчдын зургаас болж балмагдсан жолооч нар машин барихдаа айж сандардаг уу, энэ төрлийн зургийг нийтлэх шаардлагатай юу? гэсэн асуулт юм.

«Veason Journal» ослын зургийг сонинд нийтлэх тухайд бичихдээ «Хүчтэй нөлөөний улмаас гэнэт нас барах нь олонх тохиолдолд зам тээврийн ослоос болдог. Үе мөч хугарах, тээврийн хэрэгсэл эвдэрч сүйдэх нь наад захын хэрэг. Ийм зураг хүний оюун ухаанд “аюулгүйн дүрмээ баримтлахгүй яав даа” гэх бодлыг суулгаж өгдөг. Ийм цочирдом зураг нэлээд олон төрөлтэй байдаг бөгөөд тэдгээрээс нэг нь л өөрийн аюулгүй байдлыг бодоход уншигчийг уриалан

дууддаг. Өөрөөр хэлбэл ийм явдал танд ч тохиолдож болно шүү дээ гэсэн мессежийг илгээж байдаг» гэжээ.

«News Photographer» сэтгүүлийн ажилтан Майкл Д. Ширир эмгэнэлт үйл явдлын зургийг авах талаар фото сэтгүүлчдийн санал зөвлөмжийг цуглуулсан байна. Тэдний зөвлөгөө нь:

- ЗУРАГ АВАХДАА: Эртэч байх, зам тавьж өгөх, болж буй үйл явдалд саад болохгүй байх. Субъект болон орчиндоо мэдрэмжтэй байх. Энэрэнгүй байх. Субъектын дургүйг хүртэл дагаж залхааж болохгүй. “Хэрэв би зургаа авахуулж байгаа бол яах бол?” гэж өөрөөсөө асуух нь зурагчны алтан дүрэм мөн» гэж «Daily Globe»-ийн Жим Герц хэлжээ.

- ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ: Орчноо мэдэрч, аль болох авсаархан техник хэрэгсэл авч явах хэрэгтэй. Мотороо орхиж, аль болох урт линз хэрэглэ.

- СОНГОЛТ: Зураг авах агшныг анхааралтай сонго. Субъект болон уншигчийн мэдрэмжид халдахгүй байхаар зураг авах өнцгөө ол.

- ХУВЦАСЛАЛТ: Зохимжтой хувцасла. «Journal Times»-ийн Марк Херцберг «Хувцаслалт гэдэг бол олон нийт болон зовлон шаналалд автсан тэдгээр хүмүүсээс биднийг хүлээн авах чухал хэсэг нь юм. Бидний олонх нь өдөр тутам гурван хос өмсөлгүйгээр илүү дээр хувцаслаж чадна» гэсэн бол, «Statesman Journal»-ийн Дэв Мусс «Зарим үед зураг хэвлэгдсэний дараах хариу үйлдэл, шалтгааныг хэлэлцэх шаардлагаар субъекттэй холбогдох хэрэг гарч болохыг бодож үзэх хэрэгтэй»³ хэмээн зөвлөжээ.

Гэрэл зурагчид оршуулгын ёслол дээр хүмүүсийн хувийн асуудлыг хүндэтгэдэг байх ёстой. Оршуулгын

ёслол бол уйтгар гуниг, зовлон шаналал юм. Тэд зурагчидтай биш, харин гэр бүл, найз нөхөдтэйгөө уй гашуу, зовлон гунигаа хуваалцаж байгаа юм. Тэдний үйл хөдлөл заримдаа мэдээ болох нь ч бий. Эрхлэгч оршуулгын ёслолыг бүхэлд нь харуулах шийдвэр гаргасан л бол албан өрөөндөө суугаа эрхлэгчийн аашилж загнахаас үл хамааран уй гашууг дамжуулж мэдээлэх хүн бол зурагчин. Ийм ёслол, үйл ажиллагааны үед зурагчин болон олон нийтийн хооронд мэргэжлийн ёс зүйн асар их ялгаа бий.

Грег Хартли энэ талаар NPPA-ийн гишүүд болон Остиний иргэдээс судалгаа авсан байна. Тэрбээр судалгаанд хамрагдсан бүлэг бүрийн тухайн нөхцөл дэх ёс зүйг олж илрүүлэхийг зорьсон байна. Жишээ нь оршуулгын ёслолд оролцож байгаа цагдаа нар, талбайд ажиллахыг нь зөвшөөрсөн сэтгүүлчид, урилгагүй зурагчид гэх мэт. Г.Хартли уг судалгааныхаа үр дүнд нийт зурагчны 63,0 хувь нь оршуулгын ёслолын үед ёс зүйгээ сахидаг бол, олон нийтийн 85,0 хувь нь зөрчдөгийг олж тогтоосон байна. Оршуулгын ёслолд оролцож байгаа фото сэтгүүлчдийг шүүмжилдэг хүмүүс хувийн ёслолд хөндлөнгөөс оролцож байна гэж үздэг бөгөөд, зургийн үнэ цэнг ойлгодоггүй. «Вашингтон Пост» сонины Мэйри Луй Фоу оршуулгын ёслолд оролцох талаар ийнхүү зөвлөж байна.

- ЭХЛЭЭД ХОЛБОО ТОГТОО: Оршуулгын ёслолыг сурвалжлах даалгавар авсан бол эхлээд гэр бүл, эсвэл дотны найз нөхөдтэй нь холбоо барьж, очиж байгаагаа мэдэгд. Ийм уй гашуу тохиолдсонд их харамсаж байна гэх мэтчилэн энгийн байдлаар сэтгэлээ

илэрхийл. Хэрэв гэр бүлийнхэн болон найз нөхөдтэй нь ярих боломжгүй байвал оршуулгын ёслолыг ахалж байгаа хүнтэй ярь.

- ДАРУУХАН ХУВЦАСЛА: Хэрэв оршуулгын ёслолд оролцож байгаа бол зурагчин бараан өнгийн хувцас, эсвэл костюм өмсөх хэрэгтэй.

- ЭРТ ОЧ: Эрт очвол бүх хүмүүсийг хамарсан байрлалыг олж чадна.

- МОТОРОО ХЯЗГААРЛА: "Motor drive"-аа авч явах хэрэггүй. Хэдийгээр гэр бүлийн хүмүүс зөвшөөрсөн ч, уй гашууд автаж байгаа болон өөрийг чинь гэр бүлийнхний нь зөвшөөрлийг авсныг мэдээгүй хүмүүс байгааг сана.

- ГЭРЭЛ ХЭРЭГЛЭЖ БОЛОХГҮЙ: Анивчсан гэрэл хэрэглэхээс зайлсхий. Оршуулгын ёслол болж байхад гашуудаж байгаа хүмүүсийн нүүрэн дээр анивчсан гэрэл тусгах нь хамгийн бүдүүлэг хэрэг юм.

Хэзээ мэргэжлийн фото сэтгүүлч шиг байх вэ, хэзээ хариуцлагатай иргэн шиг байх вэ? Эдгээр дүрийн хооронд будилсан үед юу болох вэ? Дараах үзэгдлүүдийг жишээ болгоё. Та гудамжаар явж байгаад ломбарднаас зурагт хулгайлсан этгээдийг эзэн нь хөөж явааг харлаа. Цагдаад барьж өгөхөд нь тусалж хулгайчийг саатуулах уу, эсвэл булангаар тойрч далд орохоос нь өмнө зургийг нь авах уу?

Дараагийн өдөр нь замын хажууд осол гарсан байхыг харлаа. Нэг хүүхэд машины хянах самбарт шахагдаж, аврал хүсэн уйлж байна. Тэр бяцхан охины зургийг авах уу, эсвэл түүнийг тайтгаруулах уу?

Террорист бүлэглэл танд өөрсдийнхөө зургийг авахыг зөвшөөрлөө. Шуудхан хэлбэл тэд дэлбэрэх бөмбөг

тавих нууц даалгавраа хэрхэн биелүүлэхээ танд үзүүлэхээр шийдлээ. Та үйл явдлын зургийг авах уу, эсвэл дэлбэрэх бөмбөг идэвхжүүлэхийг нь зогсоохыг оролдох уу? Ийм нөхцөлд фото сэтгүүлчид хэрхэж байсныг эргэн саная. 1963 онд Өмнөд Вьетнамын Diem-ийн Засгийн газрыг эсэргүүцэн өөрийгөө шатаасан Буддын ламыг хэн ч зогсоох гэж оролдоогүй. Нүд хальтрам энэ зураг тухайн үеийн улс орны байдал ямар их хурц байсныг харуулахын зэрэгцээ уншигчдад эмгэнэл авчирсан. Тэр ламын үхэл улс төрийн үзэл бодлынх нь эцсийн шийдвэр байсан юм. Тухайн үйл явдлыг мэдээлсэн «Ассошиэйтэд Пресс»-ийн Петер Арнэтт «Хүний хувьд би хийхийг хүссэн ч сэтгүүлчийн хувьд чадаагүй. Харин бензинийг хол цацахаас хамгаалсан» гэж хэлсэн билээ.

Нэг хүний хувийн явдал нийт улс орны асуудал болох тохиолдол байдаг. АНУ-ын Пенсильвани мужийн Сангийн захирал Будд Дуиер 300.000 долларын хахуулийн хэргээр яллагдахаасаа хэдхэн цагийн өмнө хэвлэлийн бага хурал зарласан. 47 настай Дуиер 55 жилийн хорих ял авах байсан юм. Хэрэгтэн 30 минутын хугацаанд өөрийнхөө гэм буруугүйг сэтгүүлч, зурагчдад тайлбарласны дараа халаасаа тэмтрэн том бор дугуйтай юм гаргаж ирсэн. Түүн дотор байсан урт гол төмөртэй хар хөх өнгийн гар бууг амандаа барьж гохыг нь дарсан юм. Зурагчид, сэтгүүлчид, телевизийн хэсгийнхэн Дуиерийг зогсоож чадаагүй. Нэгд: Дуиер энэ үйлдлийг ердөө 15 секундын хооронд хийсэн юм. Хоёрт: Дуиер болон хэвлэлийнхний хооронд хаалт хийсэн байсан юм. Түүнтэй хэл амаа ололцох бололцоо ч байгаагүй.

Хэрэв тэр үед зурагчдад боломж байсан бол тэд Дуиерийг зогсоох байсан уу, Дуиер улс төрийн мэдэгдэл хийх байсан уу?

Зарим үед фото нийтлэл олон нийтийн дургүйцлийг хүргэж, энэ тухай өгүүлсэн бичвэрийг ч уншихаас зайлсхийхэд хүргэдэг. Жишээ нь сэтгэцийн өвчтэй нэгэн өөрийгөө буудсан дүр зургийг харуулах нь бараг хэрэггүй зүйл юм. Сонины эрхлэгчдийн дунд явуулсан судалгаагаар тэдний 95,0 хувь нь Дуиер өөрийгөө буудсаны дараа шалан дээр унаж байгаа зураг уншигчдыг хэтэрхий цочирдуулах зүйл болсон гэж үзсэн байна. Сонинууд түүний зургийг ямар байдлаар тавьсныг Роберт Кочерсбергер гурван мужийн сониныг хамруулан судалж үзжээ. Судалгаанд хамрагдсан сонинуудын олонх буюу 66,0 хувь нь Дуиерийн буугаа гартаа барьж байгаа зургийг нийтэлсэн байжээ. Харин буугаа амандаа хийж байгаа болон буудсаныхаа дараа шалан дээр унаж байгаа зургийг нэг ч сонин тавиагүй байна.

Улс төрийн үзэл бодлоо илэрхийлж амиа хорлохын зэрэгцээ хүнд хэлбэрийн сэтгэцийн өвчтэй хүмүүс амиа егүүтгэсэн тухай мэдээлэл хэвлэлд цөөнгүй гарах болсон юм. Техасын Вичита Файллс-д сэтгэцийн өвчтэй нэгэн 12-ын голчтой буугаар амиа хорлосон байна. Зурагчид түүнийг бас л зогсоож чадаагүй. Энэ тухай «Record News»-ийн гүйцэтгэх эрхлэгч Дон Жеймс хэлэхдээ «АНУ-д сэтгэцийн өвчин нуугдмал хэвээрээ байна. Амиа хорлож байгаа хэргийн бараг тал хувь нь буугаар амиа егүүтгэсэн байна. Сэтгэцийн өвчний маш цөөн тохиолдол

зургийн хальсанд буудаг. Цөөн ч гэсэн амиа хорлож байгаа зураг нь сэтгэцийн өвчний талаарх Америкийн бодлогын алдааг харуулж, ажил хариуцагчдын анхаарлыг хандуулахад тус дөхөм болж болох юм» гэжээ.

Хурц, хүнд зургууд редакторыг ёс зүйн хоёрдмол байдалд оруулдаг. Тэр нь аймшигтай зургуудыг харуулах уу, болих уу гэдэг эргэлзээ юм. Зургийг засч торддог редакторууд ч гэсэн бас л ёс зүйн шугамны ирэн дээр дэнжигнэж байдаг. Осол гамшгийн зураг авч байгаа фото сэтгүүлчид миний энэ зургийг сонины тэргүүн нүүрэн дээр тавихад хэтэрхий аймшигтай, хэрцгий харагдах уу, үгүй юу? гэдгийг бодох сөхөө байдаггүй. Харин зураг авч дууссаны дараа редактор судалж үзээд хэвлэхэд зохистой, эсэхийг шийддэг. Өглөөний цайгаа уух зуур «Republican Democrat»-ыг уншиж суусан уншигч эхний нүүрэнд гарсан ослын зургийг хараад аягатай кофеогоо ч асгаж мэдэх юм. Редакторууд заримдаа ийм зургуудыг “өглөөний цай шингэхэд хэцүү зураг” гэцгээдэг.

Эцэст тэмдэглэхэд редакторууд бүхнийг сайн сайхнаар дүрсэлж, амьдралыг цагаан цаас мэтээр харуулж болохгүй. Аллага, осол, дайн самуун, байгалийн гамшиг, амиа хорлох зэрэг золгүй явдлууд байнга л гарч байдаг. Энэ бүхнээс зайлсхийх нь уншигчдад тэдний аж төрж байгаа нийгмийн талаар буруу ойлголт өгөх болно. Гагцхүү жин даац,

хэм хэмжээг нь тохируулахыг л эрхэмлэх хэрэгтэй юм. Чухам ингэж чадвал нийгмийн араншинг үнэн зөв тусгахын зэрэгцээ фото сэтгүүлч ёс зүйгээ мөрдөж чадах болно.

Ишлэл

¹ Kobre K. 1996. Photojournalism: The professionals approach. Butterworth-Heinemann, p. 341.

² Lewis G. 1995. Photojournalism: Content & Technique. California, p. 48.

³ Edwards M. 1994. The complete encyclopedia of Photography. Hongkong, p. 132.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дамдин Х., Дашхүү П. 1977. Гэрэл зураг. УБ.

2. Лхагвасүрэн М. 1987. Фото нийтлэлийн төрөл зүй, өнөөгийн шаардлага. УБ.

3. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.

4. Готлоп Ф. 1981. Практика профессиональной фотографии. М.

5. Морли Д. 1982. Фотосъёмка движения. М. Edwards M. 1994. The complete encyclopedia of Photography. Hongkong.

6. Kobre K. 1996. Photo journalism: The professionals, approach. Butterworth-Heinemann.

7. Lewis G. 1995. Photojournalism: Content & Technique. California.

Summary

This article is about development of photojournalism and technological advancement and I expressed my viewpoint on importance of using this powerful media tool, which reflects life by factual evidence, ethically, quoting practice of both Mongolian and foreign photojournalists.